



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2024 оны 09 сарын 23 өдөр

Дугаар А/19

Улаанбаатар хот

Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны  
үйл ажиллагааны хөтөлбөрийн  
биелэлтийг үнэлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалт, 47 дугаар зүйлийн 47.1, 48 дугаар зүйлийн 48.1, 49 дүгээр зүйлийн 49.3 дахь хэсгийг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит ХХХ хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг хэлэлцээд 2024 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар 93.6 хувийн хэрэгжилттэй, "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж үнэлсүгэй.

2. Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг иргэд олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулахыг Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц)-т үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба (М.Давааням)-нд даалгасугай.

ДАРГА



Ф.МӨНХГЭРЭЛ